

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Мод зүсэлт аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS XXXX:XXXX
Occupational safety and health. Occupational safety. General safety requiremets for wood cutting processes.	MNS 0012-3-005:83-ын оронд

Стандарт хэмжил зүйн газрын даргын оны дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь оны.....дүгээр сарын-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь мод боловсруулах үйлдвэрийн технологийн бүхий л шатад хамаарах бөгөөд дараах хэсгүүдэд тавигдах хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ерөнхий шаардлагыг тогтооно.

2. Нэр томьёо, тодорхойлолт

2.1

Гуалин

Мод бэлтгэлийн дараа анхан шатны боловсруулалт хийгдээгүй, уртаараа хөрөөдөж тайрсан, голдуу дугуй хэлбэртэй, холтос нь бүрэн эсвэл хэсэгчлэн үлдсэн түүхий эдийг хэлнэ.

2.2

Үндсэн материал

Үйлдвэрлэлийн процесст оролцож, бүтээгдэхүүний үндсэн бүтэц, бүрэлдэхүүн хэсэг болж хувирдаг, эцсийн бүтээгдэхүүний чанар, зориулалтад шууд нөлөөлдөг материалыг хэлнэ

2.3

Хагас бэлэн бүтээгдэхүүн

Үйлдвэрлэлийн явцад тодорхой шат дамжлагад боловсруулагдсан боловч эцсийн хэрэглэгчид шууд нийлүүлэхэд бэлэн биш, цаашдын боловсруулалт шаардлагатай бүтээгдэхүүнийг хэлнэ.

2.4

Бэлдэц

Үйлдвэрлэлийн эхний шатанд түүхий эдийг боловсруулж, дараагийн шатны боловсруулалт хийхэд зориулсан, тодорхой хэлбэр хэмжээ, бүтэцтэй болсон засварын бүтээгдэхүүнийг хэлнэ.

2.5

Зүсмэл материал

Гуалингаас тодорхой хэмжээс, хэлбэр, зузаан, өргөн, урттайгаар хөрөөдөж зүссэн модон бүтээгдэхүүн.

3. Ерөнхий зүйл

3.1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь мод зүсэх, хөрөөдөх, хэлбэржүүлэх зэрэг механик боловсруулалтын үе шатанд үүсэх ажлын байрны аюултай хүчин зүйлсийг тодорхойлон, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг тогтоох, осол гэмтлээс сэргийлэхэд оршино.

4. Технологийн процесст тавих шаардлага

4.1 Мод зүсэх технологийн процессыг, тоног төхөөрөмж, машин механизмыг ашиглалтын дүрэм, үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийн үйлчлэлээс ажиллагсдыг хамгаалах шаардлагын дагуу зохион байгуулах ёстой.

4.2 Мод зүсэх дамжлагад технологийн тоног төхөөрөмжийг хэт ачаалал үүсгэхгүй байхаар ажиллуулж, зогсоох ба аль нэг суурь машин буюу механизмыг зогсоох тохиолдолд өмнөх суурь машин буюу механизмыг нэгэн зэрэг зогсоох ёстой.

4.3 Гуалингийн штабель өрөх ба буулгах ажлыг механикжуулсан байх шаардлагатай. Гуалингийн штабель өрөх ба буулгахад хэрэглэх өргөх механизм нь гуалин баригч / грейфер, эрүүт баригч/ өөрөө тайлагдагч аргамж болон бусад аюулгүй ажиллагааг хангасан хэрэгслээр тоноглогдсон байх ёстой.

4.4 Гуалин холтослох суурь машин /гуалин зөөвөрлөгчийг оруулаад/ хөрөөний агрегат ба гуалин боловсруулах шугамын удирдлага нь алсын удирдлагатай байх ба удирдах пультаг машин, механизмуудыг ажлыг хянаж байхад хамгийн тохиромжтой газар, байрлуулсан байна. Агрегат ба шугамууд нь “Пуст” товч дээр дарснаас хойш хөдөлгүүр ажиллах хүртэл 10 сек-ийн турш анхааруулах дохио өгөх зориулалттай автомат гэрэл ба дуут дохиоллоор тоноглогдсон байх ёстой.

4.5 Технологийн нэг шугамд цуваа байрлалаар байрласан бүлэг зөөвөрлөгчийн ажиллагаа нь хүлээн авагч зөөвөрлөгчийн ажилласны дараа дамжуулагч зөөвөрлөгчид дараалан ажиллах ба зогсоох ажиллагаа нь үүний урвуу байхаар тэдгээрийн удирдлагыг зохион байгуулсан байх ёстой.

4.6 Үйлдвэрлэлийн өөр өөр байранд байрласан технологийн нэг шугамд ажиллаж байгаа тоног төхөөрөмжийн ажиллах , зогсоох дохионд гэрэлтэй, дуут дохиоллыг ашиглах нь чухал юм.

4.7 Зүсмэл материалын штабелийг өргөх ба буулгахад хэрэглэх кран нь ачаа унахаас хамгаалсан ачаа баригч автомат болон механик хэрэглэлээр тоноглогдсон байх ёстой.

4.8 Гуалин болон зүсмэл материалын штабелийг өргөх ба буулгах үед кранчин ажлын талбайг сайн харж байх ба ажиллагсдын дээгүүр ачаа өргөхгүйгээр

байрлалыг болгосон байх ёстой.

4.9 Мод зүсэх үйлдвэр дэх ачиж буулгах ажлыг MNS 5366 стандартын шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

4.10 Онц аюултай болон аваарын нөхцөл байдалтай ажил жишээ нь: /хазайсан буюу нурсан гуалингийн штабелийг буулгах/ тэрчлэн цахилгаан хэлхээний хүчдэлийн гэнэтийн тасралт буюу уналтын үед гүйцэтгэх ажил нь үйлдвэрийн захиргаанаас боловсруулж баталсан, ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах журмын дагуу хийгдэнэ

4.11 6 ба түүнээс дээш баллын салхи /9,9-12,4м/ с, ширүүн бороо, өтгөн манан, гүн цастай, үзэгдэх хязгаар 50 м-ээс бага байх үед гуалин болон зүсмэл материалын штабелийг задлах хураах тэрчлэн ачиж буулгах ажиллагаа явуулахыг хориглоно

4.12 Зүсмэл материалыг зохих журмын дагуу ижил эсэргүүцэлд оруулна. Ижил эсэргүүцлийн уусмал бэлтгэх, зүсмэл материалыг уусмалд оруулах ажлыг механикжуулсан байх ёстой.

4.13 Зүсмэл материалыг хатаалгад өрөх ажлыг механикжуулсан байх ёстой. Гараар өрөх штабелийн өндөр нь 1,5м-ээс илүүгүй байх ёстой.

5. Үйлдвэрлэлийн байр, талбайд тавих, шаардлагууд

5.1 Үйлдвэрлэлийн байр, талбай нь MNS 3561 шаардлагыг хангасан байх ёстой.

5.2 Ажлын байр, шуугианы түвшин, мод зүсэх үйлдвэрлэлийн ажлын байрны бичил цаг уурын /агаарын температур, харьцангуй чийглэг, агаарын урсгалын хурд/ нөхцөл ажлын байрны байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, ахуйн байр, ариун цэвэр, өрөөнүүд нь “үйлдвэрийн барилга төлөвлөлтийн эрүүл ахуй норм”-ын шаардлагыг хангасан байх ёстой.

5.3 Мод зүсэх үйлдвэрийн байр, талбай, ахуйн болон ажилчдын байруудад зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны баталсан модон материалын агуулах, галын аюулгүйн норм -ийн дагуу гал унтраах хэрэгслүүдийг байрлуулсан байх ёстой.

5.4 Ажиллаж байгаа тоног төхөөрөмжөөс хамгаалах зориулалт бүхий 1м-ээс багагүй өргөнтэй гүүрийг мод зүсэх цехийн байрны дунд хэсэгт хөндлөн байрлуулсан байна. Гүүр, түүний шатны хоёр тал заавал хашлагатай байх ёстой. Шатыг байнга ашиглах үед шат 0.8-1.0м өргөнтэй, 450-аас ихгүй налуутай цөөн ашиглах үед /ээлжид 1-2 удаа/ 0.6-0.8м өргөнтэй , 600-аас ихгүй налуутай байх ёстой. 450-ийн налуутай үед гишгүүрийн өргөн 0.2 м, 600-ийн налуутай үед 0.3м байх түүнийг бөөрөнхий гадаргуутай металаар хийхийг хориглоно.

5.5 Мод зүсэх үйлдвэрийн байранд засвар монтажийн ажлын зориулалт бүхий 20кг-аас дээш даацтай өргөх механизм байрлуулсан байх шаардлагатай.

5.6 Мод зүсэх үйлдвэрлэлийн байр, талбайд ажиллагсдын болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг замын хөдөлгөөний болон аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан байгууллагын удирдлагаар баталсан схемийн дагуу зохион байгуулна.

5.7 Барилга, байгууламж, материалын штабелийн ойролцоо төмөр замтай огтлолцож байгаа автомашины замын дэргэд аюулгүй байдлыг хангах гэрэлтэй дуут автомат дохио ба хаалт хамгаалалтыг заавал байрлуулсан байх ёстой.

5.8 Ажлын ба байнгын хөдөлгөөнтэй өргөх зөөх машин, механизмд /авто ачигч, авто кран, өөрөө буулгагч гинжит кран гэх мэт/ зориулагдсан талбай нь тэдгээрийн ачааллыг даахаар хатуу хучилттай байх ба төмөр зам руу тулж очсон хэсэгт нь рельсийн өндөртэй тэгш байх ёстой.

5.9 Үйлдвэрийн орчинд 2 урсгалтай авто замын өргөн 6 м, 1 урсгалтай замын өргөн 3 м-ээс тус тус багагүй байх ба замын мурийсан хэсгийг зохих хэмжээгээр өргөтгөж өгсөн байх ёстой

6. Үндсэн материалд тавих шаардлага

6.1 Модон материалын ижил эсэргүүцэлд хэрэглэгдэх химийн бодисыг норматив техникийн баримт бичигт заасан дагуу бүртгэлжүүлэн хадгална.

6.2 Ажлын байрны зохион байгуулалт, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн байршилд тавих шаардлага

6.3 Мод хөрөөдөх үйлдвэрүүдийн цехэд суурилагдсан тоног төхөөрөмжийн байршил MNS 3325 шаардлагыг хангасан байх ёстой.

6.4 Хөрөө рам буюу тээвэрлэх агрегатуудын хоорондох зай 1,5м-ээс багагүй байна.

6.5 Суурь машинд материал өгөх зөөвөрлөгчийн тэнхлэг суурь машины тавцангийн тэнхлэгээс боловсруулж буй материалын өргөний хэмжээнээс багагүйгээр хэвтээ хавтгайд шилжсэн байх ёстой.

6.6 Технологийн тоног төхөөрөмжийг эрүүл ахуйн нормын хязгаараас ихгүй доргионыг ажлын байранд дамжуулж байхаар тооцоологдсон суурь болон доргионоос хамгаалах зориулалт бүхий байгууламж дээр угсрах нь зүйтэй.

6.7 Холтослох ба тайрах машиныг тусгай байранд байрлуулах, эсвэл тэдгээрийг ажлын байрнаас дуу тусгаарлах хаалтаар тусгаарлавал зохино.

6.8 Ажлын байрнаас модны хаягдлыг зайлуулах ажлыг механикжуулсан байх ёстой. Суурь машинаас гарч байгаа хаягдлыг бүрэн зөөвөрлөх тэрчлэн үйлдвэрлэлийн ба ажлын байрыг цэвэрлэхэд тохиромжтой нөхцөл бүрдүүлэх зорилгоор чиглүүлэгч, хаалт гулсуулагч ховил болон төвлөрсөн сорох системийг ашиглах нь зүйтэй.

6.9 Ажлын байранд хүрэх зам, гарц, гүүр шат тэрчлэн тоног төхөөрөмжийн ойролцоох талбай нь гулсалт багасгах зориулалттай хэрэглэлээр тоноглогдсон байна.

7. Гуалинг тээвэрлэх, ачих, буулгах, хадгалахад тавих шаардлага

7.1 Гуалингийн тээвэрлэлт

7.1.1 Гуалинг хөндлөн буюу дагуу гинжтэй зөөвөрлөгчөөр зөөнө.

7.1.2 Дагуу гинжтэй зөөвөрлөгчөөс гуалинг буулгахдаа зөөвөрлөгчийн тэнхлэгт өнцөг үүсгэн байрласан механик шидэгчийг ашиглана.

7.1.3 Дагуу гинжит зөөвөрлөгч ба гидрлоткууд нь 1м-ээс багагүй өргөнтэй 1м-ийн өндөр хашилттай гүүртэй байх ёстой. Ийм гүүрийг зөөвөрлөгчийн уртын 30м, гидрлоткын уртын 50м тутамд байрлуулах ёстой.

7.2 Гуалинг ачих, буулгах

7.2.1 Бүх төрлийн тээврийн хэрэгсэлд Гуалинг ачих, буулгах ажил механикжсан байх ёстой. Ачих буулгах ажлын хэмжээ бага байгаа онцгой тохиолдолд тээврийн ганцаарчилсан хэрэгсэлд ачигч ажиллуулахыг зөвшөөрч болох ба уг ажлыг хоёроос дээш ачигч гүйцэтгэх ёстой

7.2.2 Буулгасан ба ачихаар бэлтгэсэн гуалинг төмөр зам ойролцоо зайд овор хэмжээний хязгаарт байрлуулж бэхэлсэн байх ёстой.

7.2.3 3м-ээс урт гуалинг авто тээврийн хэрэглэлээр зөөхдөө чиргүүл, хагас чиргүүлийг ашиглана.

Гуалин ачихад зориулагдсан автомашины тавцангийн хашлаганы оронд ачаа унахаас хамгаалсан, авагддаг шонгууд бэхлэгдсэн байх тэдгээр нь ачааг даруулах боломжтой байх ёстой. Гуалинг шонгоос өндөр ачиж болохгүй. Чиргүүл дээр гуалинг ачихдаа түүнийг автомашинтай харьцангуйгаар хоёр тийшээ 900-аар чөлөөтэй эргэж байхаар кабины ар талын хана, ачаа хоёрын хооронд зай үлдээсэн байх ёстой. Автомашины тормозлох ба хөдөлгөөний үед ачааг кабин руу гулсуулахгүйн тулд гуалинг автомашинд хөдөлгөөнгүй бэхэлж, ачааг чиргүүлийн тэвштэй тэнцүү хэмжээтэй байхаар ачих хэрэгтэй.

7.3 Гуалинг хадгалах

7.3.1 Гуалингийн штабель өрөх талбай ба агуулахын төлөвлөлт нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 429 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын шаардлагыг хангасан байх ёстой.

7.3.2 Дэр модгүй гуалингийн штабелийг өрөх ба буулгахдаа дараах механизмыг ашиглана. Үүнд:

- Хүний оролцоогүй ажил гүйцэтгэхэд зориулагдсан грейфер болон бусад хэрэглэлээр тоноглогдсон кран
- Эрүүт баригчтай ачигч;
- Штабелийг өрөх ба буулгах ажлын аюулгүй ажиллагааг хангахад зориулагдсан механик гуалин баригч болон өөрөө тайлагддаг аргамжаар тоноглогдсон эргүүлэг

7.3.3 Штабелийн өндөр нь өргөгдсөн гуалингийн бүтэн хагасын уртаас ихгүй байх ёстой. Эргүүлгээр өрж байгаа дэргүй /нягт/ штабелийн хамгийн өндөр нь 8м-ээс хэтрэхгүй байх ёстой. 5.5м ба түүнээс дээш дундаж урттай холтослогдоогүй гуалингийн нягт эгнээгээр кранаар өгөгдсөн /нягт өргөгдсөн үеийн хооронд дэр модтой/ штабелийн өндөр нь 10 м-ээс, дэр модгүй өргөгдсөн холтосгүй гуалингийн штабелийн өндөр нь 12м-ээс тус тус ихгүй байх ёстой.

7.3.4 Штабелийг өрөхдөө доорх шаардлагыг мөрдөх ёстой. Үүнд:

- Штабелийн хоорондох зай, нэг штабельд өргөгдсөн гуалингийн уртын зөрөө, штабелийн хоёр талаарх гуалингийн үзүүр, ёзоорын байрлалт нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 429 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын шаардлагыг хангасан байх ёстой;
- Гуалин ба дэр модыг штабелийн дагуу тэнхлэгт тэгш хэмтэй өрсөн байх;
- Штабельд хөндлөн тавигдаж байгаа дэр моднуудын хоорондох зай хамгийн богино гуалингийн уртаас 0,5 м-ээр бага байх;
- Штабелийн дагуу байрлалтай, дэр моднуудын захын хоёр төгсгөлүүд штабелийн 2 захаас 1м-ээс багагүй хэмжээгээр дутуу тавигдсан байх;
- Гуалингуудыг хооронд нь шахаж байрлуулахын тулд дэр модон дээр заадас гаргах шаардлагатай ба заадасны гүн нь дэр модны зузааны 1/3-ээс ихгүй байх
- Нягт эгнээгээр өргөгдсөн штабельд үе бүрийн гадаргууг хотгор байхгүйгээр тэгшлэх;
- Дэр модны хоорондох хатуу, барзгар холтостой гацуур болон бусад төрлийн модон үеийн өндөр 1.2 м-ээс зөөлөн гөлгөр холтостой нарс болон бусад модон үеийн өндөр 0.9 м-ээс холимог модон үеийн өндөр 1.0 м-ээс тус тус ихгүй байх ёстой;
- Штабелийн доод хагаст орох дэрэнд 0.18м-ээс багагүй зузаантай гуалинг ашиглана.
- Штабелийн хамгийн бага урт нь түүний өндрийг 4 дахин авснаас багагүй байх ёстой.
- Штабелийн захын гуалингууд нь дэр модны заадаст суусан байх ба заадасны гүн нь суусан гуалингийн зузааны хагасаас ихгүй байх ёстой.

7.3.5 Дэргүй, нягт эгнээ болон багц гуалингаар өргөгдсөн штабелийн төгсгөлүүдэд гуалинг өөрөө нурах, өнхрөхөөс хамгаалсан багана хийсэн байх ба түүнийг дэр модтой холбож бэхэлнэ. Тийм багана байхгүй тохиолдолд штабелийн 2 үзүүрийн налуу нь 30-350-иас хэтрэхгүй байх ёстой.

7.3.6 Зөөвөрлөгч түүнд хамгийн ойр штабелийн хоорондох зай штабелийн өндрөөс багагүй ба аль ч нөхцөлд 5м буюу түүнээс дээш байх ёстой.

7.3.7 Зөөвөрлөгч түүнд хамгийн ойр штабелийн хоорондох зай штабелийн өндрөөс багагүй ба аль ч нөхцөлд 5м буюу түүнээс дээш байх ёстой.

8. Зүсмэл материалыг тээвэрлэх, ачих буулгах, хадгалахад тавих шаардлага

8.1 Зүсмэл материалыг тээвэрлэх

8.1.1 Зүсмэл материалыг өрөх, багцлах, тээвэрлэхдээ MNS 2378 шаардлагыг хангасан байх ёстой.

8.1.2 Зүсмэл материалыг мод тээврийн автомашинаар тээвэрлэхдээ хавтгай гадаргуутай 2-оос доошгүй ивээс дээр тавих ба ивээсний хэмжээ нь авто

машины өргөнтэй тохирч байх ёстой.

8.1.3 Зүсмэл материалыг автомашин, чиргүүл, хагас чиргүүл дээр ачих, зөөх буулгах үед тэдгээрийг гулсах, унахаас хамгаалж бэхлэх зориулалт бүхий хэрэгслийг хэрэглэх нь зүйтэй.

8.1.4 Зүсмэл материал тээвэрлэх автомашины кабин хамгаалалтын хэрэглэлээр тоноглогдсон байна.

8.2 Зүсмэл материалыг хадгалах

8.2.1 Зүсмэл материалыг байгалийн хатаалтад өрөх, складын төлөвлөлт нь зохих стандартын шаардлагыг хангах ёстой

8.2.2 Зүсмэл материалын штабелийн суурийн дам нурууг хөдлөхөөс хамгаалж, түүний доорх тулгуурын дунд хэсэгт бэхэлгээ хийх нь зүйтэй.

8.2.3 4м-ээс дээш урттай, эгнээгээр ба багцаар өргөгдөх зүсмэл материалын штабелийн өндөр нь 12м-ээс ихгүй, өргөн нь 7м-ээс багагүй байх ёстой. 3-4м-ийн урттай зүсмэл материалын штабелийн өндөр нь 7м-ээс ихгүй, өргөн нь 4м-ээс багагүй байна. 3м-ээс бага урттай зүсмэл материалын штабелийн өндөр нь 4м-ээс ихгүй байна. 4м-ээс дээш урттай зүсмэл материалыг гараар өрөх үед штабелийн нь 4м-ээс ихгүй байх ёстой.

8.2.4 Зүсмэл материалын штабелийг гараар өрөх, буулгах үед ажилчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн аюулгүй ажиллагааг хангасан дараах төхөөрөмж, хэрэгслийг ашиглана. Үүнд:

- Зүсмэл материалыг штабельд өрөхөд зориулагдсан эрэгдэг тулгуур багана;
- Зүсмэл материалыг штабелаас буулгахад зориулсан чиглүүлэгч.

8.2.5 Авто ачигчаар ачиж байгаа зүсмэл материалын багцыг штабель дээр гараар өрөхдөө багцын тогтвортой байрлал аюулгүй байдал болон задлахад хялбар байх нөхцөлийг хангах тусгай бэлтгэсэн ивээсийг тавих шаардлагатай.

8.2.6 Эгнээгээр өрөгдсөн штабель дээр ажиллагсад гарах ба буух үед зөөврийн шатыг ашиглах нь зүйтэй Штабелийн шатны төгсгөлөөр гарах хэмжээ 0.6-0.8м налуу нь 45- 600 байх ёстой. Банзан гишгүүрийн зузаан нь 0.04м-ээс өргөн нь 0.14м-ээс тус тус багагүй байна. Шатны үзүүрийн хэсэгт түүний бөх бат чанарыг бууруулсан яр, өмх зэрэг зүйл байж болохгүй.

8.2.7 Багцаар өрөгдсөн штабель дээр ажилтнуудыг гарахад баригч, өргөх кран дээр байрлуулсан тусгай хэрэгслийг / эвхэгддэг сандал, суудал,/ ашиглана. Тийм хэрэгсэл байхгүй тохиолдол багцын босоо эгнээнүүдийн хооронд зөөврийн шатыг тавьж ашиглах нь зүйтэй.

8.2.8 Багц штабелуудыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 429 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын шаардлагыг хангасан байх ёстой.

8.2.9 Штабелийн багцуудын хоорондох дэр модны хэмжээ ба хэлбэр нь шаардлага хангасан байх ёстой ба түүний уртын хамгийн богино хэмжээ нь 3- н багцын өргөний нийлбэрээс багагүй байх ёстой.

8.2.10 Хатаалтад өрөгдөж байгаа штабелийн багцуудад /хэвтээ эгнээ бүрд/

байх дэр модны тоо нь штабелийн суурийн доорх дам нурууны тоотой тохирч байх ёстой. Хэвтээ эгнээний хоорондох дэр моднуудыг суурийн дам нуруун дээр нэг босоо хавтгайд байрлуулах ёстой.

8.2.11 Зүсмэл материалын штабелийг авто ачигчаар өрөх үед 1-р босоо эгнээнд 3-аас илүүгүй багцыг тавина. Штабелийг дунд хэсгээс эхэлж өрөх үед эхний босоо эгнээнд ижил өндөртэй багцыг тавина. Авто ачигчаар өрөгдөж байгаа зүсмэл материалын штабелийн өндөр 7м-ээс ихгүй байх ёстой.

8.3 Зүсмэл материалыг ачих.

8.3.1 Зүсмэл материалыг бүх төрлийн тээврийн хэрэгсэлд ачих буулгах ажил механикжсан байх ёстой. Тээврийн ганцаарчилсан хэрэгсэлд ачиж, буулгах ажлын хэмжээ бага тохиолдолд уг ажиллагааг гараар гүйцэтгэхэд зөвшөөрнө.

8.3.2 Зүсмэл материалыг төмөр замын тээвэрт ачих ажлыг зохих норматив техникийн баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

8.3.3 Зүсмэл материалыг хагас вагон болон тавцанд ачихдаа ачааны дээд хэсгийг/малгай хэлбэртэй/ хоёр талаасаа багассан хэлбэрээр ачна.

8.3.4 Хос хагас вагон ба тавцан дээр ачиж буулгах ажлыг нэгэн зэрэг хийхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд тэдгээрийн хоорондох зай хагас вагон буюу тавцангийн уртаас багагүй байх ёстой.

8.3.5 Зүсмэл материалыг хагас вагон ачихдаа төмөр замын дагуу ачих хэсэгт тавигдсан гүүрийг ашиглах нь зүйтэй. Гүүрийн өндөр нь хагас вагоны хашлагатай тэнцүү, өргөн нь 1м-ээс багагүй ба шат, хоёр талын хаалт хашилт заавал байх ёстой.

9. Мэргэжлийн ажилтнуудад тавих шаардлага

9.1 Мод зүсэх үйлдвэрлэлд ажиллах ажилтнуудыг ажилд орохын өмнө урьдчилан сэргийлэх үзлэгт оруулсан байх ёстой.

9.2 Үйлдвэрлэлийн ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулсан байх.

10. Ажилтнуудын ажлын хувцас хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага

10.1 Мод зүсэх үйлдвэрүүдийн ажилтнуудын ажлын хувцас хамгаалах хэрэгслийн ашиглалт MNS 4931 шаардлагад тохирч байх ёстой.

11. Аюулгүй ажиллагааны шаардлагын биелэлтэд тавих хяналт

11.1 Техник, ариун цэвэр, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангах хяналтын үзлэг, параметруудийг хангах хэмжих хэрэгслийг туршилт зэргийг зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 429 дугаар тушаалын 2 дугаар хавсралт” модон материалын агуулах, галын аюулгүйн норм норматив техникийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.

11.2 Талбай, гүүр, шатны ачаа даах гол элементүүдийн бөх бат чанарыг статистик ачааллаар туршиж, тооцоогоор баталсан байх ёстой.

ТӨГСӨВ.